



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ФИЛАРМОНИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/203/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261685 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Захирал: Д.Баатарсайхан
Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
6. Албан шаардлага.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УФ	Улсын филармони
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ФИЛАРМОНИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ С.БАТТУЛГА
ТАНАА

2022.02.25 № 07/402
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын филарманийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын филарманийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	186,721,543.95	184,364,048.00
33	АВЛАГА	36,478,365.95	10,800,710.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,398,200.00	3,451,200.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	34,677,679.00	5,079,510.00
335	Бусад авлага	402,486.95	2,270,000.00
3351	Байгууллагаас авах авлага	402,486.95	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	2,270,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	23,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	23,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	150,243,178.00	150,563,338.00
351	Түүхий эд материал	63,336,169.00	67,271,169.00
35110	Тусгай зориулалттай материал	63,336,169.00	67,271,169.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	33,750,000.00	1,540,000.00
354	Хангамжийн материал	53,157,009.00	81,752,169.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	2,640,070.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	21,309,310.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	2,105,900.00
35470	Бусад хангамжийн материал	53,157,009.00	55,696,889.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	761,900,988.80	1,796,484,474.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	761,900,988.80	1,796,484,474.82
392	Биет хөрөнгө	761,900,988.80	1,795,254,474.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	351,800,000.00	351,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(95,118,000.00)	(124,550,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,361,874,403.67	2,224,867,548.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(923,027,633.50)	(715,241,563.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,502,908.00	86,150,504.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,330,689.49)	(29,372,013.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,799,999.88)	(6,399,999.84)
393	Биет бус хөрөнгө	0.00	1,230,000.00
39301	Програм хангамж	3,668,000.00	1,440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,668,000.00)	(210,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	948,622,532.75	1,980,848,522.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,196,293.99	103,644.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,196,293.99	103,644.35
413	Өглөг	15,196,293.99	103,644.35
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	103,644.35
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	400.00	-
4136	Бусад өглөг	15,195,893.99	-
41361	Байгууллагад төлөх өглөг	14,991,320.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	204,573.99	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	933,426,238.76	1,980,744,878.47
51	Засгийн газрын хувь оролцоо	933,426,238.76	1,980,744,878.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	390,738,376.57	390,738,376.57
51101	Өмч: - төрийн	390,738,376.57	390,738,376.57
512	Хуримтлагдсан үр дүн	483,727,755.80	1,565,982,877.21
51210	Өмнөх үеийн үр дүн	123,989,513.73	518,664,237.50
51220	Тайлант үеийн үр дүн	359,738,242.07	1,047,318,639.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,960,106.39	24,023,624.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	948,622,532.75	1,980,848,522.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,871,738,530.00	3,791,031,301.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	397,952,930.00	1,240,513,951.50
120	Нийтлэг татварын бус орлого	397,952,930.00	1,240,513,951.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	397,952,930.00	1,240,513,951.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	397,952,930.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		1,218,114,641.5
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		22,399,310.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,473,785,600.00	2,550,517,350.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,410,525,400.00	2,376,429,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,410,525,400.00	2,376,429,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,260,200.00	174,088,150.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс хуваарилсан хөрөнгө	-	105,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого	63,260,200.00	69,088,150.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,512,000,287.93	2,743,712,661.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,512,000,287.93	2,743,712,661.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,409,081,685.93	2,622,271,844.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,880,814,985.28	1,744,871,901.48
210101	Үндсэн цалин	1,350,622,689.00	1,319,533,407.48
210102	Нэмэгдэл	606,081.00	332,429,741.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	92,908,753.00
210105	Гэрээт ажлын хөлс	529,586,215.28	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	237,704,744.76	234,439,694.37
210201	Тэтгэврийн даатгал	164,866,063.71	165,221,165.84
210202	Тэтгэмжийн даатгал	19,283,902.93	17,833,597.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,104,124.94	14,011,513.29
210204	Ажилгүйдлийн даатгал	3,384,365.00	3,397,588.37
210205	Эрүүл мэндийн даатгал	35,066,288.18	33,975,829.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,800.00	41,260,000.00
210304	Байрны түрээс	41,260,800.00	41,260,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,537,260.00	14,426,580.00
210401	Бичиг хэрэг	2,788,950.00	2,818,180.00
210402	Тээвэр, шатахуун	3,660,400.00	3,816,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,440,900.00	5,402,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,647,010.00	2,389,700.00
2105	Нормативт зардал	1,229,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,229,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,805,274.00	9,500,000.00
210604	Урсгал засвар	12,805,274.00	9,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,133,434.00	300,432,400.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,605,794.00	294,102,040.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	410,000.00	2,590,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	343,440.00	372,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	262,400.00	361,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	426,200.00	2,941,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,600.00	-

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,596,187.89	277,341,268.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	87,215,613.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,596,187.89	190,125,655.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,918,602.00	121,440,817.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,045,486.00	103,155,087.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,742,686.00	58,727,087.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,302,800.00	44,428,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,873,116.00	18,285,730.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	18,285,730.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,873,116.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	359,738,242.07	1,047,318,639.71
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	359,738,242.07	1,047,318,639.71

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,738,376.57	83,325,265.01	99,624,355.11	573,687,996.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	24,365,158.62	24,365,158.62
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,738,376.57	83,325,265.01	123,989,513.73	598,053,155.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(24,365,158.62)	-	(24,365,158.62)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	359,738,242.07	359,738,242.07
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,738,376.57	58,960,106.39	483,727,755.80	933,426,238.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	34,936,481.70	34,936,481.70
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,738,376.57	58,960,106.39	518,664,237.50	968,362,720.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(34,936,481.70)	-	(34,936,481.70)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	390,738,376.57	24,023,624.69	518,664,237.50	933,426,238.76
Тайлант үеийн үр дүн	-	-	1,047,318,639.71	1,047,318,639.71
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	390,738,376.57	24,023,624.69	1,565,982,877.21	1,980,744,878.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,512,161,800.00	2,565,833,829.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,900,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	14,900,000.00	-
120009	Бусад орлого	14,900,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,497,261,800.00	2,565,833,829.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,410,525,400.00	2,376,429,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,410,525,400.00	2,376,429,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	86,736,400.00	189,404,629.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	105,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	81,736,400.00	84,404,629.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,498,952,892.00	2,559,239,329.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,498,952,892.00	2,559,239,329.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,361,356,611.00	2,432,719,002.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,786,548,589.00	1,749,484,694.03
210101	Үндсэн цалин	1,299,529,818.00	1,324,146,200.03
210102	Нэмэгдэл	404,922,180.00	332,429,741.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,096,591.00	92,908,753.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,934,054.00	229,826,122.34
210201	Тэтгэврийн даатгал	228,977,527.00	160,607,593.81
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	17,833,597.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	14,011,513.29
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	3,397,588.37
210205	Эрүүл мэндийн даатгал	18,956,527.00	33,975,829.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,400.00	41,260,400.00
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,011,430.00	32,572,879.00
210401	Бичиг хэрэг	3,365,200.00	5,218,250.00
210402	Тээвэр, шатахуун	3,660,400.00	5,921,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,440,900.00	5,402,700.00
210404	Ном, хэвлэл	185,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,359,930.00	15,850,029.00
2105	Нормативт зардал	3,109,000.00	1,439,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,109,000.00	1,439,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,028,474.00	13,000,000.00
210604	Урсгал засвар	14,028,474.00	13,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243,464,664.00	365,135,506.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	241,904,524.00	352,805,146.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	410,000.00	2,590,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	343,440.00	372,060.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	262,400.00	361,300.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,700.00	8,941,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,600.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,596,281.00	126,520,327.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,045,486.00	103,155,087.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,742,686.00	58,727,087.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,302,800.00	44,428,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,550,795.00	23,365,240.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	18,285,730.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,550,795.00	5,079,510.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,208,908.00	6,594,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,208,908.00	6,594,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,208,908.00	6,594,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,208,908.00	6,594,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,208,908.00	6,594,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,208,908.00)	(6,594,500.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,376,429,200.00	2,358,143,470.00	18,285,730.00	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,376,429,200.00	2,358,143,470.00	18,285,730.00	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,297,374,100.00	2,279,088,383.00	18,285,717.00	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,751,449,700.00	1,749,484,694.03	1,965,005.97	99.9
210101	Үндсэн цалин	1,324,244,500.00	1,324,146,200.03	98,299.97	100.0
210102	Нэмэгдэл	332,813,100.00	332,429,741.00	383,359.00	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,392,100.00	92,908,753.00	1,483,347.00	98.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,895,700.00	229,826,122.34	16,069,577.66	93.5
210201	Тэтгэврийн даатгал	173,037,700.00	160,607,593.81	12,430,106.19	92.8
210202	Тэтгэмжийн даатгал	18,214,500.00	17,833,597.33	380,902.67	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,571,600.00	14,011,513.29	560,086.71	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,642,900.00	3,397,588.37	245,311.63	93.3
210205	Эрүүл мэндийн даатгал	36,429,000.00	33,975,829.54	2,453,170.46	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,260,400.00	41,260,400.00	-	100.0
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,155,400.00	17,152,500.00	2,900.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,527,200.00	2,718,250.00	(191,050.00)	107.6
210402	Тээвэр, шатахуун	2,421,900.00	2,421,900.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,802,700.00	3,802,700.00	-	100.0
210404	Ном, хэвлэл	182,900.00	180,000.00	2,900.00	98.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,220,700.00	8,029,650.00	191,050.00	97.7
2105	Нормативт зардал	1,439,400.00	1,439,400.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,439,400.00	1,439,400.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240,173,500.00	239,925,266.63	248,233.37	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	238,317,400.00	238,304,906.63	12,493.37	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	410,000.00	410,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	474,000.00	372,060.00	101,940.00	78.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	425,600.00	361,300.00	64,300.00	84.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	66,000.00	14,000.00	82.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	411,000.00	411,000.00	-	100.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	55,500.00	0.00	55,500.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,055,100.00	79,055,087.00	13.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,055,100.00	79,055,087.00	13.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,727,100.00	58,727,087.00	13.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,328,000.00	20,328,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,376,429,200.00	2,358,143,470.00	18,285,730.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,376,429,200.00	2,358,143,470.00	18,285,730.0	100.0
122005	Орон нутгийн төсвөөс	2,376,429,200.00	2,358,143,470.00	18,285,730.0	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	150	150	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	135	135	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14	14	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	189,404,629.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		189,404,629.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		160,225,119.00
210401	Бичиг хэрэг		2,500,000.00
210402	Тээвэр, шатахуун		3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,820,379.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,954,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,954,500.00
210604	Урсгал засвар		13,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		115,700,240.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,180,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,970,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		24,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		24,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		24,100,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,079,510.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		5,079,510.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	189,404,629.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		189,404,629.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		105,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		84,404,629.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын филарманийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторов туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Ж.Ням-Осор, захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын филарманийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын филармони нь урлаг соёлын үйл ажиллагаа явуулдаг, Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Улсын филармони үйл ажиллагааны чиглэл нь соёл урлагийн тоглолт, соёл урлагийг нийтэд таниулж, түгээн дэлгэрүүлэх юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө;
 - Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
 - Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзсэн. Гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд Соёлын яамны дотоод аудитын газраас шилэн дансны хэрэгжилтийг шалгаснаар хангалттай гэж үнэлсэн боловч 2021 онд нийт оруулбал зохих 170 мэдээллээс худалдан авах ажиллагааны 99,160.4 мянган төгрөг, батлагдсан орон тооны өөрчлөлтийг 7 дугаар сард, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, батлагдсан төсөв зэрэг 4 мэдээллийг хугацаа хоцроосон зэргээс дотоод аудит үр нөлөөгүй байна.

Байгууллага нь дотоод аудитын орон тооны тусдаа ажилтан байхгүй бөгөөд хяналт шалгалтыг зохион байгуулахдаа нийтлэг журмын дагуу нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгон ажилдаг.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын филарманийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,512,000.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,120.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улсын филарманийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,032,226.0 мянган төгрөгөөр буюу 108.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	36,478.3	10,800.7	(25,677.6)
Урьдчилж гарсан зардал	-	23,000.0	23,000.0
Бараа материал	150,243.2	150,563.3	320.1
Үндсэн хөрөнгө	761,901.0	1,796,484.5	1,034,583.5
Нийт хөрөнгө	948,622.5	1,980,848.5	1,032,226.0
Өр төлбөр	15,196.3	103.6	(15,092.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	933,426.2	1,980,744.9	1,047,318.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	948,622.5	1,980,848.5	1,032,226.0

Авлага дансны үлдэгдэл 10,800.7 мянган төгрөг болж 25,677.6 мянган төгрөгөөр буурсан нь 9,000.0 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагаар нэмэгдэж, өмнөх оны 34,677.6

мянган төгрөгийн авлагыг барагдуулсан. Авлага дансны үлдэгдэлд удаан жилийн насжилттай авлага байхгүй байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 23,000.0 мянган төгрөг болж өссөн нь тоглолтын хувцас болон цахим тоглолтын цуврал контент хийлгэх ажлын урьдчилж төлсөн зардал байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,563.3 мянган төгрөг болж, 320.1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 3,935.0 мянга, бичиг хэргийн материал 2,640.1 мянга, сэлбэг хэрэгсэл 21,309.3 мянга, түлш шатах тослох материал 2,105.9 мянга, бусад хангамжийн материал 2,539.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, бэлэн бүтээгдэхүүн 32,210.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Байгууллагын онцлогоос шалтгаалж хөгжмийн зэмсгийн туслах материалуудын дансны үлдэгдэл ихтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,796,484.5 мянган төгрөг болж 1,034,583.5 мянган төгрөгөөр өссөн нь Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 1,240,513.9 мянган төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер, тоног төхөөрөмжөөр нэмэгдэж, урсгал төсвөөс 6,594.5 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, санхүүгийн программ худалдан авсан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2021 оны 468 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөнөөс элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 363,296.4 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, 190,125.6 мянган төгрөгөөр элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,092.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны байгууллагад өгөх өглөг барагдуулсантай холбоотой байна.

Улсын филарманийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 919,292.8 мянган төгрөгөөр буюу 32.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 1,240,513.9 мянган төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 231,712.4 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж (182,299.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гэрээт уран бүтээлчдийн ажлын хөлстэй холбоотой), бараа үйлчилгээний бусад зардал (87,215.6 мянган төгрөг) зэрэг зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,376,429.2 мянган төгрөгөөр, урсгал зардалд 2,376,429.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,376,429.2 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,376,429.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,376,429.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,376,429.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,358,143.5 мянган төгрөг зарцуулж, 18,285.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 2,358,143.5 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс ба нэмэгдэл урамшуулалд 1,749,484.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 229,826.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 41,260.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 17,152.5 мянган төгрөг, норматив зардалд 1,439.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 239,925.3 мянган төгрөг тэтгэвэр тэтгэмж, нэг удаагийн тэтгэмж шагналд 79,055.1 мянган төгрөгийг батлагдсан төсвийн дагуу бүрэн зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 2 арга хэмжээнд 18,285.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,060,014.1	2,041,740.9	18,273.2	99.1
2	80103	Гэрээгээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээ	130,000.0	130,000.0	-	100.0
3	80214	Уран бүтээл хийлгэх	107,360.0	107,347.5	12.5	99.9
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	79,055.1	79,055.1	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас Соёлын сайдын А/50 тоот тушаал, Тайзны бүрэн хэмжээний уран бүтээл туурвих /Эрхт монгол/ концертын санхүүжилт 105,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 84,404.6 мянга, нийт 189,404.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 160,225.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 24,100.0 мянга, нийт 184,325.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,079.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын филарманийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлийг 82 хувьтай тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд зориулан нийт 2,376,429.2 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,358,143.5 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.2 хувь байна.

Цар тахлын хорио цээрийн дэглэмийн үед үзвэр үйлчилгээний үзэгчдийн тоо буурах, төлөвлөгөөт тоглолтууд цуцлагдаж үндсэн үйл ажиллагааны орлого буурсантай холбогдуулан Соёлын яамнаас чиглэл өгсний дагуу цахим орчинд соёл түгээе ажлын хүрээнд тоглолтуудыг цахим орчинд түгээсэн контентын зардалд 45,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитаар Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт оруулбал зохих 170 мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан орон тооны өөрчлөлтийг 7 дугаар сард, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, батлагдсан төсөв зэрэг 4 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг хэрэгжүүлж 29,751.7 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,028.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд 89 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	1	-	1	-	1	-	78.0
Зөвлөмж	2	21,028.0	2	21,028.0	-	-	100.0
Нийт дүн	3	21,028.0	3	21,028.0	-	-	89.0

Өмнөх оны аудитаар шилэн дансны 34 мэдээлэл хоцроон байршуулсанд албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагын биелэлтийг бүрэн биелүүлээгүй гэж үзсэн болно.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар цахим контентуудаас үүсэх үр дүнг анхаарч авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 187,992.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 185,428.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,563.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2,563.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 25,120.0 мянган төгрөгөөс хэтрээгүй байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээний 35,747.0 мянган төгрөгийн зардлын тооцооны дансыг буруу бүртгэн цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгэсэн,
- Ажил олгогчоос төлсөн 125,116.7 мянган төгрөгийн НДШ-ийн зардал дансны тооцооны дансыг цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх 1,200.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг бараа материалын дансанд бүртгэсэн байсныг тус тус залруулав;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 23,365.2 мянган төгрөгийг залруулав.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд бичиг хэргийн 2,563.4 мянган төгрөгийн зардлыг тогтмол зардлын тооцооны дансаар дамжуулан бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар

зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 14 дүгээр зүйлийн 14.3 “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх “ гэсэн заалтуудыг зөрчсөн, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулж, нягтлан бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Улсын филармони	АХГ-2022/203/НА-СТА-ТШЗ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээний 35,747.0 мянган төгрөгийн зардлын тооцооны дансыг буруу бүртгэн цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгэсэн	Тооцооны дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	35,747.0	1	35,747.0						
2			Ажил олгогчоос төлсөн 125,116.7 мянган төгрөгийн НДШ-ийн зардал дансны тооцооны дансыг цалингийн тооцооны дансаар дамжуулан бүртгэсэн	Тооцооны дансыг зөв бүртгэх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	125,116.7	1	125,116.7						
3			Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх 1,200.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг бараа материалын дансанд бүртгэсэн	Хөрөнгийн ангиллыг зөв хөтлөх зөвлөмж өгч залруулга хийлгэсэн	1	1,200.0	1	1,200.0						
4			Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 23,365.2 мянган төгрөгийг тохируулга хийгээгүй.	Төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулга хийлгэсэн	1	23,365.2	1	23,365.2						
5			Бичиг хэргийн 2,563.4 мянган төгрөгийн зардлын тооцоог тогтмол зардлын тооцооны дансаар дамжуулан бүртгэж тооцоо хийсэн	Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан тул зөвлөмж хүргүүлэх	1	2563.4							1	2,563.4
	ДҮН				5	187,992.3	4	185,428.9					1	2,563.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Улсын филармони	АХГ-2022/203/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 170 мэдээлэл оруулахаас 4мэдээлэл хугацаа хоцроосон мэдээлсэн байна	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх	1						1			
	ДҮН				1						1			
НИЙТ ДҮН					6	187,992.3	4	185,428.9	0	0	1		1	2,563.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 267 / АО/50458

Улаанбаатар хот

АХГ-2022/203/НА-СНА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Улсын филарманийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн системд хуулийн дагуу байршуулах 170 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.2.4 "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын филарманийн захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баттулгад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Л.АМАРЗАЯА

0010800817

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

[illegible]